

РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ



RICHWELL
ENGINEERING LLC

ЭРЧИМ ХУЧНИЙ ЗУРАГ ТӨСӨЛ | ЭРЧИМ ХУЧНИЙ БАРИЛГА УГСРАЛТ | РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТЖУУЛАЛТ

RICH IN KNOW HOW, RICH IN SUCCESS



RICHWELL
ENGINEERING LLC

< АЛСЫН ХАРАА >

Бид орчин үеийн инженерийн баялаг мэдлэг, чадвар хуримтлуулж түүгээрээ Монгол хүний сайн сайхан ирээдүйг бүтээхийн төлөө тэмүүлнэ.

< ЭРХЭМ ЗОРИЛГО >

Бид инженерийн иж бүрэн шийдлээр хангаж үнэ цэнийг бий болгоно

РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНИГ

Инженерийн баялаг мэдлэгээр сайн сайхныг бүтээнэ





RICHWELL
ENGINEERING LLC

РИЧВЕЛЛ ИНЖЕНЕРИНГ ХХК

Ричвелл Инженеринг ХХК нь 2012 онд эрчим хүч,уул уурхайн дэд бүтэц, үйлдвэрлэлийн салбарт мэргэжлийн инженеринг, зураг төсөл гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, төслийн удирдлага, барилга угсралт, материал тоног төхөөрөмж нийлүүлэлт зэрэг ажил үйлчилгээ үзүүлэх зорилготой байгуулагдсан.

Байгуулагдсан цагаас эхлэн өөрийн туршлагатай мэргэжилтэн, инженер техникийн ажилтнуудын ур чадвар, орчин үеийн шинэ техник технологийг ашигласан инженерингийн цогц шийдлийг санаачлах, зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга угсралтын ажил гүйцэтгэх, хүлээлгэн өгөх гэсэн бүрэн үйлчилгээг үзүүлж ажиллаж байна.

Түүнчлэн бид эрчим хүчний салбарт хэрэгжүүлж буй төслүүдэд захиалагчийн хяналт гүйцэтгэх, техникийн шийдэл боловсруулах, арга зүйн зөвлөгөө өгөх, төслийн менежментийг үр дүнтэй гүйцэтгэх орчин үеийн аргачлалын талаар зөвлөх үйлчилгээг үзүүлдэг.

Бизнесийн үндсэн чиглэлийн дагуу олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй компаниудтай хамтран ажилласнаар үзүүлж буй үйлчилгээг дэлхийн стандарт жишигт хүргэхээр зорьж ажиллаж байна. Компани байгуулагдсанаасаа хойш төрөл бүрийн тоног төхөөрөмж нийлүүлэлт болон барилга угсралтын төслүүдийг захиалагчийн шаардлагад бүрэн нийцүүлэн амжилттай хэрэгжүүлээд байна.

Мөн инженерингийн төвөгтэй шийдэл шаардсан, техникийн нарийн мэдлэгт суурилан сонголт хийж, шийдэл боловсруулах, зураг төсөл гүйцэтгэх орчин үеийн шинэ технологи бүхий тоног төхөөрөмжийг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор ажиллаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Бид орчин үеийн инженерийн баялаг мэдлэг, чадвар хуримтлуулж түүгээрээ Монгол хүний сайн сайхан ирээдүйг бүтээхийн төлөө тэмүүлнэ.



ЗУРАГ ТӨСӨЛ



**ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА
УГСРАЛТ**



**РЕЛЕ ХАМГААЛАЛТ,
АВТОМАТЖУУЛАЛТ**




БИДНИЙГ СОНГОХ ШАЛТГААН

Манай компани нь нийт 80 гаруй инженерийн бүрэлдэхүүнтэй ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа бөгөөд үүнд Эрчим хүчний салбарт 15-30 жил ажилласан зөвлөх болон мэргэшсэн инженерүүд баг хамт олноо ахалж дэд бүтцийн салбарт бүрэн инженерингийн шийдэл боловсруулж, бүтээн байгуулалтыг гардан хийж байна.



Эрчим хүчний эх үүсвэр болон инженерийн шугам сүлжээний ТЭЗҮ ажлын зураг



0.4-110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын болон кабел шугам, дэд станцын угсралт



Цахилгаан цэнэгт хуримтлуурын систем, реактив чадлын компенсаторийн шийдэл




Иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийн иж бүрэн ажлын зураг төсөл



Реле хамгаалалт автоматжуулалт болон үйлдвэрийн процессын автоматжуулалтын угсралт, туршилт тохируулга



Гадаадын туршлагатай компаниудтай хамтран орчин үеийн стандартад нийцсэн шийдэл боловсруулах, зураг төслийн орчуулгыг өндөр түвшинд гүйцэтгэнэ





ЗУРАГ ТӨСӨЛ

Ричвелл Инженеринг ХХК-н Инженеринг зураг төслийн газар нь компани үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн ажлын зураг төсөл боловсруулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Эрчим хүчний эх үүсвэр, дулаан болон цахилгаан хангамжийн

Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил үйлчилгээ үзүүлсээр байна. Зураг төслийн газар нь олон жилийн туршлагатай мэргэжилтэн, инженер техникийн ажилтнуудын ур чадвар дээр үндэслэн орчин үеийн шинэ техник технологийг ашигласан инженерингийн цогц шийдлээр, барилга


байгууламж, ерөнхий төлөвлөгөө болон инженерингийн иж бүрэн ажлын зураг төсөл, зохиогчийн хяналт, ТЭЗҮ боловсруулах ажил гүйцэтгэх, хүлээлгэн өгөх гэсэн үйлчилгээг үзүүлж ажиллаж байна.



Инженерийн баялаг мэдлэгээр сайн сайхныг бүтээнэ



Дулаан, цахилгааны эх
үүсвэрийн ажлын зураг
төсөл, ТЭЗҮ



Дэд бүтцийн шугам
сүлжээний ажлын зураг
төсөл

- УХАТ
- ДУЛААН ХАНГАМЖ
- ЦАХИЛГААН ХАМГАМ
- ХОЛБОО



Хот төлөвлөлт, барилга
байгууламж, ерөнхий
төлөвлөгөөний ажлын
зураг төсөл



Зураг төслийн зохиогчийн
хяналт




Реле
хамгаалалт,автоматик,
үйлдвэрийн
автоматжуулалтын зураг
төсөл



Иргэний ба үйлдвэрийн
барилга байгууламжийн
ажлын зураг төсөл

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА УГСРАЛТ



2012 оноос эхлэн Эрчим хүчний барилга угсралт бүтээн байгуулалтын чиглэлээр 0,4-110кВ-ын ЦДАШ, дэд станцууд, дулааны станц, зуух, дулааны шугам сүлжээ, үйлдвэрийн автоматжуулалтын систем зэрэг томоохон төслүүдийн барилга угсралтыг амжилттай гүйцэтгэж байна. Бид жилдээ 150 км урт ЦДАШ барьж байгуулах, 10-80 МВА чадалтай 4 дэд станц барьж байгуулах, зуух, зуухны автоматжуулалт, 16-40кгх/см² даралттай дулааны шугам сүлжээ, ЦТП-ний барилга угсралтыг хийх хүчин чадал, нөөцтэй.



Цахилгаан эрчим хүч
дамжуулах болон түгээх
шугам сүлжээ, дэд станц



Барилга угсралтын төслийн
удирдлага



Дулааны станц, дулааны
шугам сүлжээ, эрчим
хүчний байгууламжийн
угсралт



Барилга угсралтын ажлын
төлөвлөлт, хяналт



Үйлдвэрийн процессийн
автоматжуулалт




Барилга угсралтын ажлын чанрын
хяналт



Барилга угсралтын бичиг баримт бүрдүүлэлт



Зуухны автоматжуулалтын системийн угсралт



РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТЖУУЛАЛТ

БҮХ ТӨРЛИЙН ХЯНАЛТ АВТОМАТЖУУЛАЛТ, УДИРДЛАГЫН СИСТЕМ

Бид дэлхийн тэргүүлэх реле хамгаалалт, автоматжуулалт удирдлагын системүүдийг судалж шинэ технологиуд болон шийдлүүдийг салбар нэгжүүдэд амжилттай нэвтрүүлж байна. Монгол улсын эрчим хүчний системд анх удаагаа 110кВ-ын агаарын шугамын 4 төгсгөлт дагуу дифференциал реле хамгаалалтын шийдлийг нэвтрүүлж АШ-109,110-д систем үүсгэгч 7 дэд станцыг хамруулан шугамын үндсэн хамгаалалт SEL-411L релег суурилуулж ажиллагаанд оруулсан.





NR Электрик компанийн реле хамгаалалт, автоматжуулалт, HMI программ, хяналт мэдээллийн СКАДА системийг ЦДҮС ТӨХК-ийн 110/10кВ-ын 2*40МВА чадалтай “Шонхор” дэд станцад иж бүрнээр амжилттай нэвтрүүлсэн болно. NR Электрик компани нь дэлхийн эрчим хүчний систем дахь реле хамгаалалт автоматжуулалт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инженерчлэлийн салбарт 20 гаруй жилийн туршлагатай тэргүүлэгч компанийн нэг юм.

Бид NR Электрик компанийн реле хамгаалалт, автоматжуулалтын системийн бүтээгдэхүүн нийлүүлэлт угсралт, ашиглалтад оруулах туршилт болон засвар үйлчилгээ зэрэг бүх үйлчилгээг албан ёсоор үзүүлж байна.

Эрчим хүчний системд холбогдох томоохон чадлын цахилгаан цэнэгт хуримтлуурын систем, реактив чадлын компенсаторийн тооцоолол шийдэл боловсруулж, угсралт туршилт тохируулгыг хийнэ.



Төслийн нэр: Баруун-Урт дулааны станцын үнс зайлуулах систем

Захиалагч: Солонгосын Дулааны Шугам Сүлжээний Корпораци, Солонгосын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага

Төслийн товч танилцуулга: Баруун Урт дулааны станц нь 13 Гкал/ц хүчин чадалтай бөгөөд КОИКА-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд Солонгосын Даесунг Глобал Нетворк, Дова Инженеринг, Солонгосын Дулааны Шугам Сүлжээ Корпораци 2013 онд барьж байгуулсан. Төслийн дараах үзлэг шалгалтыг КОИКА болон Солонгосын Дулааны Шугам Сүлжээ Корпораци хамтран хийсний дараа станцын үнс дамжуулах систем, галын усны систем, болон станцын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сайжруулах



чиглэлээр арга хэмжээ авахаар шийдсэн.

Гүйцэтгэсэн ажил үүрэг:

Төслийн ажлын эзлэхүүнд дулааны станцын үнс зайлуулах систем, үнсний бункер-ийн зураг төсөл, материал тоног төхөөрөмж нийлүүлэлт, барилга угсралт, туршилт тохируулга хүлээлгэн өгөх ажлууд орсон. Мөн дулааны станцын ашиглалтын аюулгүй ажиллагааг сайжруулах үүднээс галын усны дулаалга, халаагч кабел суурилуулах, галын хор суурилуулах, аюулгүйн нэмэлт шат хашлага суурилуулах ажлууд хийгдсэн. Захиалагчийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үндсэн конвейроор хашлагатай, битүү конвейр сонгосон бөгөөд үнс баригчаас үндсэн бункер-руу үнсийг зөөх конвейроор шнейк сонгосон. Дулааны станцын 2 зуухнаас гарах үнсийг 2 өдөр хадгалах хүчин чадалтай уутат шүүлтүүр, доргиогч, үнс буулгагч, гар болон цахилгаан хаалт зэрэг стандарт туслах тоноглолоор тоноглогдсон 50М3-ийн үнс баригчийг сонгон суурилуулсан.



Төслийн нэр:

110/35/10 кВ
Баясгалант
дэд станцын
Аккумуляторын
төхөөрөмж, цэнэглэх
төхөөрөмжийн хамт
шинэчлэх ажлын
хүрээнд

Захиалагч: ЦДЭС ТӨХК

Төслийн товч танилцуулга:

Дэд станцын тогтмол гүйдлийн системийг олон улсын IEC стандарт шаардлагад нийцсэн орчин үеийн дэвшилтэт технологийн НМ1 хяналттай цэнэглэгч төхөөрөмж, гүн цэнэгийн батарей бүхий системээр бүрэн шинэчлэв.

Гүйцэтгэсэн ажил үүрэг: Emerson Network Power компанийн микрокомпьютер удирдлагатай тогтмол гүйдлийн цэнэглэгч төхөөрөмж, хуваарилах гаргалга бүхий 3 ширхэг панель, гүн цэнэгийн OPzV төрлийн 200 А/ц багтаамжтай батарей 108 ширхэгийг тавиурын хамт суурилуулсан.

RICHWELL

Төслийн нэр:

Төв аймаг Сэргэлэн сум Бөхөг 15 МВт-ын НЦС анхдагч тоноглолын угсралт

Захиалагч:

М Си Эс Интернейшнл ХХК

Төслийн товч танилцуулга:

Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах 15 МВт-ын хүчин чадалтай Нарны цахилгаан станцыг эрчим хүчний нэгдсэн системд холбох.

Гүйцэтгэсэн ажил үүрэг:

110/10 кВ-ын 2x16МВА чадалтай дэд станцын анхдагч тоноглолын угсралтын ажил




БАРИЛГА УГСРАЛТЫН ТӨСЛҮҮД

Төслийн нэр: 110/10 кВ-ийн Хүчит Шонхор Дэд Станц

Захиалагч: Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК

Төслийн товч танилцуулга:

Улаанбаатар хотын Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 20 мянган өрхийг цахилгаан халаагуураар халаах боломжийг бүрдүүлэх Засгийн газрын шийдвэрийн дагуу 2x40МВА чадал бүхий 110/10кВ-ын "Хүчит Шонхор" дэд станцыг бүтээн байгуулав.



ENGINEERING LLC

Гүйцэтгэсэн ажил үүрэг:

110/10 кВ, 2x40МВА трансформатор бүхий дэд станцын зураг төсөл, материал тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, барилга угсралт, туршилт тохируулгын ажил; Дэд станц, ЦДАШ-ын өөрчлөлтийн зураг төсөл, Дэд станцын барилга угсралт, Дэд станцын реле хамгаалалт удирдлага автоматжуулалт, СКАДА, НМ1, дэд станцын туршилт тохируулга хийгдсэн. Дэд станцын ил хуваарилах байгууламж, хаалттай хуваарилах байгууламж, удирдлагын өрөөнд нийт 24 цэгт хяналтын хөдөлгөөнт иж бүрэн камерын систем суурилуулсан. Дэд станц нь 40000кВА чадлын 2 хүчний трансформатор, 110кВ-ын 7 ячейк бүхий ил хуваарилах байгууламж, I ба II систем шинтэй. 10кВ-ын хаалттай хуваарилах байгууламж нь I ба II ажлын шинтэй 42 ячейк тоноглогдсон. 27000м3газар шороо ухмал байгуулах, орчны тохижилт үер усны хамгаалалтаар 2000м2 талбайн гадаргууд эко хавтан суулгалт хөрс ариутгал хийгдсэн.



Төслийн нэр:

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн үе шат-1

Захиалагч:

Улаанбаатар хотын захиргаа

**Төслийн товч танилцуулга:**

Эрхэм зорилго нь эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгоход оршино.

Гүйцэтгэсэн ажил үүрэг:


- Сэлбэ дэд төв
- Баянхошуу дэд төв
- Сэлбэ болон Баянхошуу дэд төвд цогц зураг төслийн зохиогчийн хяналтын үйлчилгээ хийж байна.

Төслийн нэр:

Дэнжийн мянга дэд төвийн 40ГКал/ц хүчин чадалтай ДС-н ТЭЗҮ

Захиалагч:

Азийн хөгжлийн банк

**Төслийн товч танилцуулга:**

Өндөр хүчин чадлын Дулаан хуваарилах төв барьж, Дэнжийн мянга дэд төвийг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох,

Оргил ачааллын үеийн дулааны бие даасан эх үүсвэрийг төвлөрсөн сүлжээтэй хослуулан ажиллуулах


Гүйцэтгэсэн ажил үүрэг: Шинээр төлөвлөж буй Дэнжийн мянга дэд төвийн 40ГКал/ц хүчин чадалтай дулааны станцыг ТЭЗҮ боловсруулсан.

Төслийн нэр:

Сүхбаатар аймгийн 5 сумын төвийн төвлөрсөн дулаан хангамжийн зураг төсөл

Захиалагч:

Сүхбаатар аймгийн ЗДТГ

**Төслийн товч танилцуулга:**

Сүхбаатар аймгийн 5 сумыг төвлөрсөн дулаан хангамжид холбох, ард иргэдийг дулаанаар хангамжаар хангахад оршино.

Гүйцэтгэсэн ажил үүрэг:

Баяндэлгэр 1183 м, Мөнххаан 2223 м, Түвшинширээт 1198.2 м, Уулбаян 1100 м урттай дулааны шугам, Зуухны ачаалал нь: Баяндэлгэр, Мөнххаан-1.6 Гкалл, Түвшинширээт, Уулбаян 1.1 Гкалл ажлын зураг төсөл

RICHWELL

ЗУРАГ ТӨСӨЛ, ИНЖЕНЕРИНГИЙН ТӨСЛҮҮД

ENGINEERING LLC

Төслийн нэр:

Монгол Улсын 10 аймгийн төвийн Дулаан хангамжийн системийг сайжруулах Төсөл

Захиалагч: Солонгосын Дулааны Шугам Сүлжээний Корпораци,

Төслийн товч танилцуулга:

Төвлөрсөн дулаан хангамжтай дулааны станц барих, Дулааны станцын үр ашгийг дээшлүүлэх, Өсөн нэмэгдэж буй хэрэгцээнд нийцүүлэн дулааны станцыг өргөтгөх, Жилийн турш хэрэглээний халуун усаар тасралтгүй хангах, Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулах, Ажлын нөхцөлийг сайжруулах

Гүйцэтгэсэн ажил үүрэг:

- Зөвлөх үйлчилгээ
- Бодит худалдан авалт (худалдан авалт болон барилга угсралт)

**Төслийн нэр:**

Сэлбэ дэд төвийн 28МВт-ын хүчин чадалтай ДС-ын ТЭЗҮ

Захиалагч:

Азийн хөгжлийн банк

Төслийн товч танилцуулга:

Хөтөлбөрийн эрхэм зорилго нь эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгоход оршино.

Гүйцэтгэсэн ажил үүрэг: Шинээр төлөвлөж буй Сэлбэ дэд төвийн 28 МВт-ын дулааны станцын ТЭЗҮ боловсруулсан.



Төслийн нэр: Өмнөговь аймгийн Ханбогд сумын ДС-ын ТЭЗҮ, зураг төсөл

боловсруулах

Захиалагч: Өмнөговь аймгийн ЗДТГ

Төслийн товч танилцуулга: Өмнөговь аймгийн Ханбогд сумын ард иргэдийг дулаан хангамжаар хангах.

Гүйцэтгэсэн ажил үүрэг: 15 МВт-ын хүчин чадалтай 40*32 дулааны станц, түлш дамжуулах хэсэг (галлерей 1,2, бутлах цех, нүүрс хадгалах саравч, харуулын байр)-ын ажлын бүрэн зураг төсөл, 15 МВт-ын дулааны станц ТЭЗҮ





RICH IN KNOW HOW RICH IN SUCCESS

Сити тауэр, 11 давхар 1103 тоот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Чингисийн талбай 5,
Улаанбаатар хот, 14200, Монгол Улс
(976) 11-311425

 info@richwell.mn

 311425

 www.richwell.mn

 Richwell Engineering